



Г ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР
Д.ДОЛЖИНСҮРЭН ТАНАА

ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хонгор 3-306 тоот, 1 дүгээр баг, Адаацаг сум,
Дундговь аймаг, 48140 Утас: (976) 7507 8787
Цахим шуудан: Adaatsag@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023.04.25 № 09/72
танай _____-ны № _____-т

Албан шаардлагын хариу
хүргүүлэх тухай

Тус газрын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 45 дугаартай “Зөрчил арилгах” тухай...тайланд хугацаанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, 30 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй...Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх/ заасныг зөрчсөн байна гэсэн албан шаардлагын дагуу дараах ажлуудыг зохион байгуулж биелэлтийг тооцож ажиллаа.

Нягтлан бодогч Ө.Уранбилэгт Засаг даргын Тамгын газрын гүйлгээтэй холбоотой мэдээллийг хугацаа хоцроохгүй шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулж 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг ажилдаа бүрэн хэрэгжүүлэх ажиллах.

Мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахдаа тухайн мэдээллийг үнэн зөв, бодитой бүрэн оруулж дээрх цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” хуулийн заалтыг нэг мөр хангасан байх.

Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг уншиж судлах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдээллийг хоцроохгүй байх, тухай бүр нь мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах зэрэг үүрэг чиглэл өгч биелэлтийг тооцож ажилласны үр дүнд 2023 оны 04 дүгээр сарын 24-ний байдлаар нийт 41 мэдээллийг байршуулахаас 41 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Мөн Тус газрын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаартай “Зөрчил арилгах” тухай “...урсгал засварын зардлаар санхүүжүүлсэн 41.935.700.00 /дөчин нэгэн сая есөн зуун гучин таван мянга долоо зуу/ төгрөгний өртөгтэй “4 айлын орон сууцны барилга”-ын ажлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн...Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1. /Шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/ 33 дугаар зүйлийн 33.1-д бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 2-т /шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд 20 сая/ заалтыг тус тус зөрчсөн байна...” гэсэн албан шаардлагын дагуу хууль, тогтоолыг хэрэгжүүлж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7¹ дугаар зүйлийн 7¹.2. “Сум, дүүргийн төсвийн

487220023

хүрээнд худалдан авах, хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно” гэсэн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хязгаарыг тогтоосон хуулийн заалтыг заавал хэрэгжүүлж ажиллах.

Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ 2. “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа, ажил 20.0” гэсэн тогтоолын заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх.

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн тогтоол зэргийг уншиж судлах тэр дундаа 2022 онд шинээр нэмэлт өөрчлөлт орсон заалтууд болон штрик заалтуудыг онцгой анхаарч судлах талаар Засаг дарга Ч.Уранчимэг, түүний орлогч Б.Марал-Үжин нарт шаардлага саналыг тавьж ажиллаа.

Одоогийн байдлаар буюу 2023 оны 04 дүгээр сарын 24-ний байдлаар 90.000.000 /ерэн сая/ төгрөгний үнэлгээтэй хог ачих зориулалт бүхий автомашины тендер зарласан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг хангаж ажилласан байна. Мөн Засгийн газрын 124 дүгээр тогтоолын 2. “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа, ажил 20.0” гэсэн заалтыг зөрчсөн тохиолдол гаргаагүй болно.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ОЧИРБАТ

